

**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

---

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-  
Шаардлага, хэрэглэх заавар**

**MNS ISO 45001 : 2018**

**Албан хэвлэл**

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР  
Улаанбаатар хот  
2018 он**

Захиалагч: "МОНГОЛРОСЦВЕТМЕТ" ТӨҮГ  
Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалтын үндэсний төв: 2021-09-20  
Монгол улсын стандарт мөн болно. Хувилан олшруулахыг хориглоно.



**ХУВИЛАН ОЛШРУУЛАХ ЭРХ НЬ ХАМГААЛАГДСАН.**

Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын нийт стандарт болон тэдгээрийг үндэсний болгон баталсан хувилбарыг хуулбарлан олшруулах эрх нь хамгаалагдсан. Иймд өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд Стандартчиллын төв байгууллагаас бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр ISO стандартын болон тэдгээрийг үндэсний болгон баталсан хувилбарын аливаа хэсгийг электрон, механик, дүрс буулгах зэрэг аливаа аргаар хуулбарлан олшруулах, ашиглахыг хориглоно. Зөвшөөрөл хүссэн хүсэлтийг

Стандарт, хэмжил зүйн газар  
Энхтайваны өргөн чөлөө 46А  
Улаанбаатар, 13343, Монгол Улс  
Э-шуудан: [standardinform@masm.gov.mn](mailto:standardinform@masm.gov.mn)  
Вэб хуудас: [www.estandard.gov.mn](http://www.estandard.gov.mn)

хаягаар эсхүл Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын дараах хаягаар хүлээн авна:

ISO copyright office  
Case postale 56  
CH-1211 Geneva 20  
Tel: + 41 22 749 01 11  
Fax: + 41 22 749 09 47  
E-mail: [copyright@iso.org](mailto:copyright@iso.org)  
Web: [www.iso.org](http://www.iso.org)

## АГУУЛГА

|  |           |
|--|-----------|
| Өмнөх үг.....  | v         |
| Танилцуулга .....  | vi        |
| <b>1 Хамрах хүрээ .....</b>  | <b>1</b>  |
| <b>2 Норматив ишлэл .....</b>  | <b>2</b>  |
| <b>3 Нэр томъёо тодорхойлолт .....</b>   | <b>2</b>  |
| <b>4 Байгууллагын төлөв байдал .....</b>   | <b>8</b>  |
| 4.1 Байгууллага ба түүний төлөв байдлыг ойлгох нь.....   | 8         |
| 4.2 Сонирхогч талууд, ажилтнуудын ба сонирхогч талуудын хэрэгцээ<br>хүлээлтийг ойлгох нь ..... | <b>9</b>  |
| 4.3 ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох .....                          | 9         |
| 4.4 ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо .....  | 9         |
| <b>5 Манлайлал ба ажилтны оролцоо .....</b>  | <b>9</b>  |
| 5.1 Манлайлал ба үүрэг амлалт.....   | 9         |
| 5.2 ХЭМАБ-ын бодлого.....  | 10        |
| 5.3 Зохион байгуулалтын үүрэг хариуцлага ба эрх мэдэл.....                                     | 11        |
| 5.4 Ажилтнуудын оролцоо ба зөвлөлдөөн .....  | 11        |
| <b>6 Төлөвлөлт.....</b>  | <b>12</b> |
| 6.1 Эрсдэл ба боломжид чиглэсэн арга хэмжээ.....   | 12        |
| 6.1.1 Ерөнхий зүйл .....   | 12        |
| 6.1.2 Аюулыг тодорхойлох эрсдэл ба боломжуудыг үнэлэх .....                                    | 13        |
| 6.1.3 Хууль тогтоомжийн шаардлага ба бусад шаардлагыг<br>тодорхойлох .....                     | 14        |
| 6.1.4 Төлөвлөх арга хэмжээ.....  | 15        |
| 6.2 ХЭМАБ-ын зорилтууд ба тэдгээрийг биелүүлэх төлөвлөлт .....                                 | 15        |
| 6.2.1 ХЭМАБ-ын зорилтууд.....  | 15        |
| 6.2.2 ХЭМАБ-ын зорилтуудыг биелүүлэх төлөвлөлт .....   | 16        |
| <b>7 Дэмжлэг.....</b>  | <b>16</b> |
| 7.1 Нөөц.....  | 16        |
| 7.2 Чадамж .....   | 16        |
| 7.3 Мэдлэг ойлголт .....   | 16        |
| 7.4 Мэдээлэл харилцаа .....  | 17        |
| 7.4.1 Ерөнхий зүйл .....   | 17        |
| 7.4.2 Дотоод мэдээлэл харилцаа .....   | 17        |
| 7.4.3 Гадаад мэдээлэл харилцаа .....   | 17        |

## MNS ISO 45001:2018

|   |           |
|---|-----------|
| 7.5 Баримтжуулсан мэдээлэл.....                                     | 18        |
| 7.5.1 Ерөнхий зүйл.....   | 18        |
| 7.5.2 Мэдээлэл бий болгох ба шинэчлэх.....                          | 18        |
| 7.5.3 Баримтжуулсан мэдээллийн хяналт .....                         | 18        |
| <b>8 Ажиллагаа .....</b>  | <b>19</b> |
| 8.1 Ажиллагааны төлөвлөлт ба хяналт.....                            | 19        |
| 8.1.1 Ерөнхий зүйл.....   | 19        |
| 8.1.2 Аюулыг арилгах ба ХЭМАБ-ын эрсдэлийг бууруулах.....           | 19        |
| 8.1.3 Өөрчлөлтийн менежмент .....                                   | 20        |
| 8.1.4 Бусдаар гүйцэтгүүлэх .....                                    | 20        |
| 8.2 Онцгой байдлын бэлэн байдал ба хариу арга хэмжээ .....          | 21        |
| <b>9 Гүйцэтгэлийн үнэлгээ .....</b>                                 | <b>21</b> |
| 9.1 Мониторинг, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээ.....                  | 21        |
| 9.1.1 Ерөнхий зүйл.....   | 21        |
| 9.1.2 Нийцлийн үнэлгээ .....  | 22        |
| 9.2 Дотоод аудит .....  | 22        |
| 9.2.1 Ерөнхий зүйл.....   | 22        |
| 9.2.2 Дотоод аудитын хөтөлбөр.....                                  | 22        |
| 9.3 Удирдлагын дүн шинжилгээ.....                                   | 23        |
| <b>10 Сайжруулалт .....</b>   | <b>24</b> |
| 10.1 Ерөнхий зүйл .....   | 24        |
| 10.2 Аюултай тохиолдол, үл тохирол ба залруулах арга хэмжээ.....    | 24        |
| 10.3 Байнгын сайжруулалт .....                                      | 25        |
| <b>А Хавсралт (мэдээллийн) Баримт бичгийг хэрэглэх заавар .....</b> | <b>26</b> |

## Өмнөх үг

ОУСБ (Олон улсын стандартчиллын байгууллага) нь үндэсний стандартын байгууллагууд (ОУСБ-ын гишүүн байгууллага)-ыг нэгтгэсэн даян дэлхийн холбоо юм. Олон улсын стандарт боловсруулах ажлыг ихэвчлэн ОУСБ-ын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Тодорхой асуудлаар зохион байгуулагдсан Техникийн хороонд уг асуудлыг сонирхсон аль ч гишүүн байгууллага төлөөллөө оролцуулах эрхтэй байна. Олон улсын байгууллагууд, төрийн ба төрийн бус байгууллагууд ОУСБ-тай хамтран энэ ажлыг гүйцэтгэхэд оролцдог. ОУСБ цахилгаан техникийн стандартчиллын асуудлаар ОУЦТК-той нягт хамтран ажилладаг.

Энэ баримт бичгийг боловсруулах, цаашид мөрдөх журмыг ОУСБ/ОУЦТК-ын Удирдамжийн 1 дүгээр хэсэгт тодорхойлсон. Тухайлбал, ОУСБ-ын төрөл бүрийн баримт бичгийг батлахад өөр өөр шалгуур байдаг гэдгийг тэмдэглэсэн. Энэ баримт бичгийг ОУСБ/ОУЦТК-ын Удирдамжийн 2 дугаар хэсэгт тодорхойлсон редакцийн дүрмийн дагуу боловсруулсан. ([www.iso.org/directives](http://www.iso.org/directives) сайтаас үзнэ үү).

Энэ баримт бичгийн зарим хэсэг зохиогчийн эрхэд хамаарч болохыг анхаарах нь зүйтэй. ОУСБ зохиогчийн ийм төрлийн болон аливаа бусад эрхийг тодорхойлох хариуцлага хүлээхгүй. Энэ баримт бичгийг боловсруулж байх явцад илэрсэн зохиогчийн аливаа эрхийн талаар танилцуулгад, эсвэл ОУСБ хүлээн авч бүртгэсэн зохиогчийн эрхийн жагсаалтад оруулна. ([www.iso.org/patents](http://www.iso.org/patents) сайтаас үзнэ үү).

Энэ баримт бичигт ашигласан аливаа барааны тэмдгийг хэрэглэгчид тохиромжтой байх зорилгоор оруулсан ба дэмжлэг үзүүлэх зорилгогүй юм.

Стандартууд нь сайн дурын байдгийг тайлбарлахын тулд, тохирлын үнэлгээнд хамаарах ОУСБ-ын онцлог нэр томъёо ба үг хэллэгийн болон ОУСБ-ын Худалдаан дахь техникийн саад тотгортой холбоотой Дэлхийн худалдааны байгууллагын зарчмыг дагаж мөрдөхтэй холбоотой мэдээллийг дараах сайтаас үзнэ үү: [www.iso.org/iso/foreword.html](http://www.iso.org/iso/foreword.html).

Энэ баримт бичгийг ОУСБ-ын Хөдөлмөрийн эрүүл мэнд ба аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, 283 дугаар төслийн хороо боловсруулсан.

Энэ стандарт нь Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын стандартыг 1:1-ээр монгол хэл дээр орчуулан, үндэсний болгосон. “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо” гэдгийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментын тогтолцоо” гэж ойлгохоор тогтов.

## **Танилцуулга**

### **0.1 Үндэслэл**

Байгууллага бүр өөрийн ажилтан болон тухайн үйл ажиллагаанд оролцдог бүх хүмүүсийн хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Энэхүү үүрэг хариуцлагад ажилтны биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаа хамаарна.

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын (ХЭМАБ)-ын менежментийн тогтолцоог бий болгохдоо байгууллага эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлж, хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалсан осол гэмтэл, өвчлөлөөс сэргийлэх ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог тасралтгүй хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **0.2 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын (ХЭМАБ)-ын менежментийн тогтолцооны зорилго**

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын (ХЭМАБ)-ын менежментийн тогтолцооны зорилго нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл ба боломжуудыг удирдах тогтоцоор хангах явдал юм.

ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны зорилго ба зорих үр дүн нь ажилтныг ажлаас шалтгаалсан осол гэмтэл, өвчлөлөөс сэргийлэх, тэднийг эрүүл аюулгүй ажлын байраар хангах явдал бөгөөд энэ нь үр дүнтэй, сэргийлж болох арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хөдөлмөрийн эрсдлүүдийг бууруулж, байгууллагыг аюулаас хамгаалах ач холбогдолтой.

Байгууллага нь дээрх арга хэмжээнүүдийг ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх замаар хэрэгжүүлснээр ХЭМАБ-ын гүйцэтгэл сайжирна. ХЭМАБ-ын гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээг эрт авч хэрэгжүүлсэнээр ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо нь илүү үр нөлөөтэй ба үр ашигтай хэрэгжих боломжтой болно.

Энэхүү баримт бичигт нийцсэн ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог хэрэгжүүлснээр байгууллагад ХЭМАБ-ын эрсдлийг удирдах, ХЭМАБ-ын гүйцэтгэлийг сайжруулах боломжийг бий болгоно.

ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо нь хууль, тогтоомжын шаардлага болон бусад шаардлагыг биелүүлэн ажиллахад байгууллагад тусална.

### **0.3 Амжилтын хүчин зүйлс**

ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх нь байгууллагын стратегийн болон үйл ажиллагааны шийдвэр болно. ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны

амжилт нь байгууллагын бүх чиг үүрэг ба түвшин дэх манлайлал үүрэг амлалт, оролцооноос хамаарна.

ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны хэрэгжилт, хэвийн ажиллагаа, түүний үр нөлөө ба зорисон үр дүнд хүрэх чадвар нь дараах гол хүчин зүйлүүдээс хамаардаг. Үүнд:

- a) Дээд удирдлагын манлайлал, үүрэг амлалт, үүрэг ба хариуцлага;
- b) ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны зорисон үр дүнд хүрэх байгууллагын соёлыг бий болгох, хөгжүүлэх, дэмжих Дээд удирдлага;
- c) Мэдээлэл харилцаа холбоо
- d) Ажилтан/ажилтны төлөөллийг оролцуулах ба зөвлөлдөх,
- e) Хэрэгжилтийг хангах шаардлагатай нөөцийг хуваарилах, бий болгох
- f) Байгууллагын үйл ажиллагааны ерөнхий чиглэл болон стратегийн зорилттой уялдсан ХЭМАБ-ын бодлого.
- g) Аюулыг олж тодорхойлох, ХЭМАБ-ын эрсдлийг хянах болон ХЭМАБ-ын боломжуудыг давуу тал болгон ашиглах үр нөлөөтэй үйл явц,
- h) ХЭМАБ-ийн гүйцэтгэлийг сайжруулахын тулд ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны гүйцэтгэлийн байнгын үнэлгээ, мониторинг;
- i) ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог байгууллагын үндсэн үйл ажиллагаатай уялдуулах,
- j) ХЭМАБ-ын бодлогод нийцсэн ХЭМАБ-ын зорилтууд ба байгууллагад учирч болох аюул, ХЭМАБ-ын эрсдлийн болон ХЭМАБ-ын боломжуудыг харгалзан үзэх;
- k) Шаардлагууд болон хууль тогтоомжийн бусад шаардлагуудыг биелүүлэх,

Энэхүү баримт бичгийг хэрэгжүүлснээр ХЭМАБ-ын үр нөлөөтэй менежментийн тогтолцоо бий болгосоноо ажилтан болон сонирхогч талуудад нотлон харуулна.

Энэхүү баримт бичгийг хэрэгжүүлсэн хэдий ч ажилтны ажил хөдөлмөрөөс шалтгаалсан осол гэмтэл, өвчлөлөөс бүрэн сэргийлэх баталгаа болохгүй ч ажлын байрны эрүүл, аюулгүй байдлыг хангах ХЭМАБ-ын гүйцэтгэлийг сайжруулна.

Байгууллагын ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны амжилтыг хангахад шаардагдах нөөц ба баримтжуулсан мэдээллийн хэр хэмжээ, нарийвчлал, төвөгтэй байдал нь дараах хүчин зүйлсээс хамаарна. Үүнд:

- Байгууллагын төлөв байдал (жишээ нь, ажилтны тоо, цар хэмжээ, газарзүйн байдал, байгууллагын соёл, хууль тогтоомжийн болон бусад шаардлага),
- ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны хамрах хүрээ;
- Байгууллагын үйл ажиллагаа түүнтэй холбоотой ХЭМАБ-н эрсдэлүүдийн мөн чанар,

#### **0.4 Төлөвлө – Хий – Шалга – Сайжруул**


Энэхүү баримт бичигт тусгасан ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны арга нь Төлөвлө – Хий – Шалга - Сайжруул (ТХШС) гэсэн үзэл баримтлал дээр тулгуурладаг.

## MNS ISO 45001:2018

ТХШС гэсэн үзэл баримтлал нь байгууллагын үйл ажиллагааг байнга сайжруулахад чиглэсэн давтагдах үйл явц юм. Үүнийг элемент бүрээр нь бичвэрийг тайлбарлан дараах байдлаар менежментийн тогтолцоонд хэрэглэж болно.

- а) Төлөвлө: ХЭМАБ-ын эрсдэл, боломжууд болон бусад эрсдэл, боломжуудыг тодорхойлох, үнэлэх, Байгууллагын ХЭМАБ-ын бодлогод холбогдох үр дүнг авчрахад шаардагдах ХЭМАБ-ын зорилтууд ба үйл явцуудыг тогтоох;
- б) Хий: Төлөвлөсөн үйл явцыг хэрэгжүүлэх;
- с) Шалга: ХЭМАБ-ын бодлого ба ХЭМАБ-ын зорилтуудадтай хамааралтай үйл явц болон үйл ажиллагаанд мониторинг, хяналт хийх, үр дүнг тайлагнах;
- д) Сайжруул: Зорьсон үр дүнд хүрэхийн тулд ХЭМАБ-ын гүйцэтгэлийг байнга сайжруулж арга хэмжээ авна.

Энэхүү баримт бичигт багтсан ТХШС (PDCA) гэсэн үзэл баримтлалыг шинэ тогтоцод нэгтгэснийг 1-р зурагт үзүүлэв.



Тайлбар Хаалтанд өгөгдсөн дугаараар баримт бичигт дэлгэрэнгүйг оруулав.

Бүдүүвч 1. - ТХШБ болон баримт бичгийн хоорондох уялдаа холбоо.

1-Р ЗУРАГ. ТХШС болон энэ баримт бичгийн тогтоц хоорондын хамаарал



Бичвэрийн тайлбар: Хаалтанд буй тоонуудаар энэ баримт бичгийн бүлгийн дугааруудыг үзүүлсэн.

### **0.5 Энэ баримт бичгийн агуулга**

Энэхүү баримт бичиг нь ISO-гийн менежментийн тогтолцооны стандартын шаардлагуудад нийцэж байгаа болно. Эдгээр шаардлагуудад дээд эрэмбийн бүтэц, үндсэн цөм агуулга болон нийтлэг нэр томъёог үндсэн тодорхойлолтуудтай нь багтаасан бөгөөд олон төрлийн ISO менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлж буй хэрэглэгчдэд ашиг тустай.

Энэ баримт бичиг нь чанарын, нийгмийн хариуцлагын, байгаль орчны, аюулгүй байдлын болон санхүүгийн менежментийн гэх мэт асуудалд хамаарах онцлог шаардлагыг агуулаагүй боловч элементүүд нь хоорондоо нарийн зохицолдоотой, бусад менежментийн системтэй нягт уялдаатай юм.

Энэхүү баримт бичигт байгууллага нь ХЭМАБ-менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх, тохирлын үнэлгээг хийхэд хэрэглэж болохуйц шаардлагуудыг тусгасан. Байгууллага энэхүү баримт бичгийн тохирлыг хангахдаа дараах арга замыг хэрэглэнэ:

- өөрөө өөрийгөө тодорхойлох болон өөрийгөө тунхаглах, эсвэл
- байгууллагыг хэрэглэгч зэрэг сонирхогч талууд өөрсдийн тохирлыг нотлохыг эрэлхийлэх, эсвэл
- байгууллагын гаднах байгууллага өөрийгөө тодорхойлсныг нотлохыг эрмэлзэх
- ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулах/бүртгүүлэх.

Энэ баримт бичгийн 1-3-р зүйлд баримт бичгийн хамаарах хамрах хүрээ, норматив ишлэл, нэр томъёо, тодорхойлолтыг оруулсан ба 4-өөс 10-р зүйлд энэхүү баримт бичигт тохирч буйг үнэлэхэд ашиглах шаардлагуудыг тусгасан болно. Хавсралт А-д эдгээр шаардлагуудын нэмэлт Бичвэрийн тайлбаруудыг оруулсан. Гуравдугаар бүлэгт нэр томъёо тодорхойлолтыг үзэл баримтлалын дарааллаар, баримт бичгийн төгсгөлд цагаан толгойн үсгийн дарааллын индексжүүлж оруулсан.

Энэ баримт бичигт үйл үг дараах үг хэллэгээр төгссөн бол:

- а) "... на, ... но, ...нэ, ...нө" гэж төгссөн бол шаардлагыг илэрхийлнэ;
- б) "... зохино" гэж төгссөн бол зөвлөмжийг илэрхийлнэ;
- с) "... боломжтой" гэж төгссөн бол зөвшөөрлийг илэрхийлнэ;
- д) "... болно" гэж төгссөн бол боломж буюу чадавхийг илэрхийлнэ.

"Бичвэрийн тайлбар" гэж тэмдэглэгдсэн мэдээлэл нь холбогдох шаардлагыг ойлгох буюу тодруулах зааварчилгаа болно. 3-р бүлэгт хэрэглэгдэж буй "Бичвэрийн тайлбар" гэсэн тэмдэглэгээ нь тухайн холбогдох нэр томъёог ашиглахад шаардлагатай нэр томъёоны нэмэлт мэдээллийг илэрхийлнэ.

## **MNS ISO 45001:2018**

Энэ стандартыг “ДАТ Консалтинг” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, “Эс Эф Си Эс” ХХК-ны гүйцэтгэх захирал Л.Тунгалаг, “Ажил Олгогч Эздийн Холбоо”-ны дэд ерөнхийлөгч Х.Ганбаатар, СХХ-ийн дарга Р.Ганхуяг, Монсертф ХХК-ийн Ерөнхий захирал Г.Билгүүн, тэргүүлэх аудитор Р.Бумдарь нар орчуулан, Ш.Отгонбилэгийн нэрэмжит технологийн их сургуулийн захирал профессор С.Давааням хянасан бөгөөд Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцөлд хүрсэн тул Стандартчиллын Үндэсний Зөвлөлийн хуралдаанаар батлуулсан болно.